

ЦАХИМ ЭРҮҮЛ МЭНД ТӨСЛИЙН 2017 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ – 1: Цахим эрүүл мэнд хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагаа

1.1. Олон улсын зөвлөхүүдийн ажлын удирдамж боловсруулах, хөлслөх.

Цахим эрүүл мэндийн урт хугацааны олон улсын зөвлөх болон Энтерпрайз архитектур (ЭА)-ын олон улсын зөвлөхүүдийн ажлын удирдамжийг боловсруулан ЭМЯ-нд танилцуулсан. Олон улсын зөвлөхүүдийг сонгон шалгаруулах "Үнэлгээний хороо" байгуулж ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын А/39 тоот тушаалаар 2 дугаар сарын 15-нд баталсан. Үнэлгээний хорооны хурлыг 2 дугаар сарын 16-нд хийж, олон улсын зөвлөхүүдийн удирдамжуудыг баталсан. Олон улсын зөвлөхүүдийн удирдамжуудад Дэлхийн банкны зөвшөөрлийг авч, 2 дугаар сарын 24-нд UN Development Business (UNDB) online-д бүртгүүлж, зарлал гаргасан. Нийтдээ ЭА-ын зөвлөхийн сонгон шалгаруулалтад оролцох сонирхлоо илэрхийлсэн 6 этгээдэд, Цахим Эрүүл мэндийн зөвлөхийн зарын дагуу 10 хүнд материал илгээсэн. 3 дугаар сарын 16-ны өдөр өргөдөл хүлээж авах хугацаандаа Энтерпрайз архитектурын олон улс(ОУ)-ын зөвлөхийн 4 материал хүлээж авсан. Мөн 3 дугаар сарын 17-ны өдөр Цахим эрүүл мэндийн ОУ зөвлөхийн 7 материал хүлээж авсан. Ирүүлсэн өргөдөл материалуудад үнэлгээ хийж, Дэлхийн банкны өгсөн зөвшөөрлийн дагуу сонгон шалгарсан зөвлөхтэй гэрээний нөхцлөө тохиролцож, гэрээ байгуулсан. Цахим эрүүл мэндийн олон улсын урт хугацааны зөвлөх Димитрис 9, 11 дүгээр сард Монголд ирж ажилласан. Энтерпрайз архитектурын олон улсын зөвлөх 9 дүгээр сард Монгол улсад ирж ажилласан.

1.1. Дотоодын зөвлөхүүдийн ажлын удирдамж боловсруулах, хөлслөх

"Мэдээллийн технологийн болон эмнэлгийн тоног төхөөрөмж, програм хангамж, сүлжээ, хүний нөөцийн өнөөгийн байдлын судалгаа"-ны дотоодын 2 зөвлөхүүдийн ажлын удирдамжийг боловсруулан ЭМЯ-нд танилцуулсан. Судалгааны 2 дотоодын зөвлөхүүдийг сонгон шалгаруулах "Үнэлгээний хороо" байгуулж, Төрийн нарийн бичгийн

даргын А/42 тоот тушаалаар 2 дугаар сарын 16-нд баталсан. Үнэлгээний хорооны хурлыг 2 дугаар сарын 17-нд хийж, дотоодын зөвлөхүүдийн удирдамжуудыг баталсан. Дотоодын зөвлөхүүдийн удирдамжуудад Дэлхийн банкнаас зөвшөөрөл авахаар 2 дугаар сарын 24-нд хүргүүлсэн. ДБ-аас зөвшөөрөл ирсний дараа зарыг дотоодын “Өнөөдөр” болон “Өдрийн сонин”-д 3 дугаар сарын 6-ны өдөр нийтэлсэн. Мөн уг зарлалаа ЭМЯ-ны вэбсайтад байрлуулсан. Өргөдөл хүлээж авах хугацаандаа буюу 3 дугаар сарын 20-ны өдөр Эмнэлгийн тоног төхөөрөмжийн 6 горилогчоос, Мэдээллийн технологийн зөвлөхөд 12 горилогчоос материал хүлээж авсан. Сонгон шалгаруулалт хийж, Дэлхийн банкны зөвшөөрлийг авч, сонгон шалгарсан дотоодын 2 зөвлөхтэй ЭМЯ-ны ТНБД 5 дугаар сарын 30-ны өдөр хөлсөөр ажиллах гэрээ байгуулсан. Эрүүл мэндийн өгөгдлийн, цахим эрүүл мэндийн хуулийн, өгөгдлийн стандарт боловсруулах дотоодын 3 зөвлөхүүдийн ажлын удирдамжийг боловсруулан, ЭМЯ-нд танилцуулсан. Дотоодын 3 зөвлөхүүдийг сонгон шалгаруулах “Үнэлгээний хороо” байгуулж, Төрийн нарийн бичгийн даргын А/41 тоот тушаалаар 2 дугаар сарын 16-нд баталсан. Үнэлгээний хорооны хурлыг 2 дугаар сарын 17-нд хийж, дотоодын зөвлөхүүдийн удирдамжуудыг баталсан. Дотоодын зөвлөхүүдийн удирдамжуудад Дэлхийн банкнаас зөвшөөрөл авахаар 2 дугаар сарын 24-нд хүргүүлсэн. Эрүүл мэндийн өгөгдлийн стандартын дотоодын зөвлөхийн ажлын удирдамж боловсруулан, зарлан, сонгон шалгаруулж, гэрээ байгуулан 11-р сарын 10-ны өдрөөс ажилдаа орсон. Эрүүл мэндийн өгөгдлийн дотоодын зөвлөхийн ажлын удирдамжийг боловсруулж, давтан зарыг өдөр тутмын “Өнөөдөр” болон “Өдрийн сонин”-гуудад нийтэлсэн. Хүмүүс материал ирүүлээгүй тул анхны шалгарсан хүнтэй гэрээ байгуулах саналыг Дэлхийн Банкинд хүргүүлсэн. Эрүүл мэндийн өгөгдөл солилцох стандартын болон цахим эрүүл мэндийн хуулийн дотоодын зөвлөхүүдийн ажлын удирдамжийг боловсруулан ДБ болон ЭМЯ-нд санал авахаар хүргүүлсэн.

- 1.2. “Энтэрпрайз архитектурын програм хангамжийн лиценз” худалдан авах
“Энтэрпрайз архитектурын програм хангамжийн лиценз” худалдан авах олон улсын нээлттэй тендерийн ажлын удирдамж, тавигдах техникийн

шаардлагыг боловсруулж ЭМЯ-нд танилцуулсан. “Энтэрпрайз архитектурын програм хангамжийн лиценз” худалдан авах олон улсын нээлттэй тендерийн сонгон шалгаруулах үнэлгээний хороог ЭМЯ-ны ТНБД-ын 6-р сарын 09-ний өдрийн А/142 тоот тушаалаар баталсан. Дэлхийн банкнаас худалдан авах ажиллагааг хойшлуулсан.

1.3. Судалгаа зохион байгуулах

Төслийн хүрээнд хийх “Мэдээллийн технологийн болон эмнэлгийн тоног төхөөрөмж, програм хангамж, сүлжээ, хүний нөөцийн өнөөгийн байдлын судалгаа”-ны хамрах хүрээг ЭМЯ-ны мэдээллийн технологийн мэргэжилтэнтэй хамтран санамсаргүй түүвэрлэлтийн аргаар тодорхойлсон. Судалгаанд хамрагдах 7 аймгийн нэгдсэн эмнэлэг, 35 сумын эрүүл мэндийн төв (ЭМТ), 14 өрхийн ЭМТ, 2 дүүргийн нэгдсэн эмнэлэг, 2 улсын нэгдсэн эмнэлгийн жагсаалтыг гарган, төслийн захирлын 5 дугаар сарын 30-ны өдрийн ТЗ/01 тоот тушаалаар батлуулсан. Судалгааг 2017 оны 7-9 дүгээр саруудад зохион байгуулсан. Судалгаанд 7 аймгийн эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг, 35 сумын, 7 өрхийн эрүүл мэндийн төв зэрэг эрүүл мэндийн 70 гаруй байгууллагууд хамрагдсан. Судалгааны дүнг 11-р сарын 14-ний өдөр салбарын мэдээллийн технологийн мэргэжилтнүүд, 12-р сарын 6-ны өдөр статистик мэдээллийн ажилтнуудыг оролцуулан хэлэлцүүлсэн. Энэ судалгааны үр дүнг үндэслэн манай орны 550 гаруй анхан шатны эрүүл мэндийн байгууллага сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг тус бүр 4 компьютерээр хангахаар шийдвэрлэсэн.

1.4. Эрүүл мэндийн салбарын энтэрпрайз архитектур, харилцан үйлчлэлцэлийн тогтолцоог боловсруулах

“Бизнес архитектур боловсруулах”, “Өгөгдлийн архитектур боловсруулах”, “Хэрэглээний архитектур боловсруулах”, “Технологийн архитектур боловсруулах” дөрвөн тусдаа дотоодын нээлттэй тендерээр гүйцэтгүүлэхээр төлөвлөсөн байсныг нэг комданиар гүйцэтгүүлэх шаардлагатай гэдэг үндэслэлээр цахим эрүүл мэнд төслийн удирдах хорооны 2017 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн хурлын 3 дугаар тогтоолоор “Энтэрпрайз архитектур хөгжүүлэх худалдан авах

ажиллагааны сонгон шалгаруулалтын аргыг өөрчилж, Олон улсын нээлттэй тендерээр гүйцэтгүүлэх”-ээр шийдвэрлэсэн. “Эрүүл мэндийн салбарын энтэрпрайз архитектур, харилцан үйлчлэлцэлийн тогтолцоог боловсруулах” олон улсын нээлттэй тендерийн ажлын даалгаврыг боловсруулж, ЭМЯ-ны саналыг авч, дэлхийн банкны зөвшөөрөл авахаар СТЕП системд оруулсан.

1.5. Эрүүл мэндийн өгөгдлийн тайлбар толь боловсруулах

“Эрүүл мэндийн өгөгдлийн тайлбар толь боловсруулах” олон улсын нээлттэй тендерийн ажлын удирдамж боловсруулж, цахим эрүүл мэндийн олон улсын урт хугацааны зөвлөх болон энтэрпрайз архитектурын олон улсын зөвлөхийн санал, зөвлөмжийг авч, дэлхийн банкны зөвшөөрөл авахаар хүргүүлсэн.

1.6. Эрүүл мэндийн өгөгдлийн болон мэдээллийн технологийн стандарт боловсруулах

“Эрүүл мэндийн өгөгдлийн болон мэдээллийн технологийн стандарт боловсруулах” олон улсын нээлттэй тендерийн ажлын удирдамж боловсруулж, цахим эрүүл мэндийн олон улсын урт хугацааны зөвлөх болон энтэрпрайз архитектурын олон улсын зөвлөхийн санал, зөвлөмжийг авч, дэлхийн банкны зөвшөөрөл авахаар хүргүүлсэн.

БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ – 2: Эмнэлгийн өгөгдөл цуглуулах, хандах, солилцох

2.1. Нийтийн түлхүүрийн дэд бүтцийн талаар судалж, иргэний үнэмлэхний регистрийн дугаарыг өвчтөнийг таних үндсэн түлхүүр болгох боломжийн талаар санал бэлтгэх

Нийтийн түлхүүрийн дэд бүтцийн талаар судалж, иргэний үнэмлэхний регистрийн дугаараар өвчтөнийг таних түлхүүр болгох саналыг боловсруулсан. Төслийн захирлын 2017 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн 02 тоот тушаалаар "Өвчтөнийг таних үндсэн түлхүүрийн асуудлаар хамтрагч болон оролцогч талуудын төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг" зохион байгуулах хөтөлбөр, төсвийг батлуулж, хэлэлцүүлсэн. Эрүүл мэндийн нэгдсэн мэдээллийн системд үйлчлүүлэгч

өвчтөнийг ялган таних технологийн шийдэл гаргасан. Энэ шийдэл нь ЭМ-ийн мэдээллийн нэгдсэн системийн өвчтөн үйлчлүүлэгчийг ялган таних дэд систем нэвтрүүлэхэд зориулан нэмэлт зардал, цаг хугацаа шаардахгүй сайн талтай.

2.2. Эрүүл мэндийн мэдээлэл солилцооны платформын зөвлөхийн удирдамж боловсруулах

Эрүүл мэндийн мэдээлэл солилцооны платформ (ЭММСП)-ын Олон улсын болон дотоодын техникийн зөвлөхийн ажлын удирдамжуудыг боловсруулан, санал авахаар Дэлхийн банкинд хүргүүлсэн.

БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ – 3: Эрүүл мэндийн мэдээллийн үндэсний төв

3.1. ЭММҮТ-д ажиллах техникийн ажилтнуудын ажлын удирдамжийг боловсруулах

Техникийн 4 ажилтны ажлын байрны тодорхойлолтыг ЭМХТ-ийн удирдлагатай хамтран боловсруулан, цахим эрүүл мэндийн олон улсын зөвлөхийн саналыг авч, ДБ-ны зөвшөөрөл авч ЭМЯ-нд танилцуулсан. ЭМЯ өөрсдөө шууд сонгон шалгаруулж авахаа мэдэгдсэн.

БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ – 4: Байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлж, чадавхжуулах

4.1. Хэрэглэгчийн сургалтын олон улсын болон дотоодын зөвлөхийн ажлын удирдамжийг боловсруулах

Хэрэглэгчийн олон улсын зөвлөхийн ажлын удирдамж боловсруулж ЭМЯ-нд танилцуулсан. Хэрэглэгчийн олон улсын зөвлөхийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог ЭМЯ-ны ТНБД-ын 6-р сарын 09-ний өдрийн А/143 тоот тушаалаар баталсан. Дэлхийн банкнаас хэрэглэгчийн сургалтыг хойшлуулах зөвлөмж өгсөн.

4.2. Оролцогч талуудын чадавх бэхжүүлэх

2017 оны 11 дүгээр сарын 14-нд “ЭМ-ийн салбарын мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийн зөвлөлдөх уулзалт”, 12 дугаар сарын 6-нд “ЭМ-ийн статистикийн мэргэжилтнүүдийн зөвлөлдөх уулзалт”, 12

дугаар сарын 14-нд ЭМ-ийн салбарын 100 удирдах ажилтнуудыг оролцуулан “Цахим эрүүл мэнд” үндэсний зөвлөлдөх уулзалтуудыг тус тус амжилттай зохион байгуулсан.

БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ – 5: Төслийн удирдлага

5.1. Төслийн зохицуулагчийг сонгон шалгаруулж ажилд нь оруулах

Цахим эрүүл мэнд төслийн ТХН-ийн зохицуулагчийн ажлын удирдамжийг шинэчлэн боловсруулж, ЭМЯ, Дэлхийн банкны саналыг авч, Төрийн нарийн бичгийн дарга(ТНБД)-ын 4 дүгээр сарын 13-ны өдрийн А/95 тоот тушаалаар сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулсан. Төслийн зохицуулагчийг сонгон шалгаруулж, Дэлхийн банк, Сангийн яамны зөвшөөрлийг авч, гэрээ байгуулан 2017 оны 9-р сарын 11-ний өдрөөс ажиллуулж эхэлсэн.

5.2. Төслийн хэрэгжилтийн хүрээнд орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж, эмнэлгийн үйл ажиллагаатай танилцах

Хөвсгөл, Архангай, Сэлэнгэ, Завхан аймагт ажиллаж, Улаанбаатар хотод Улсын төв эмнэлгүүд, төрөлжсөн мэргэжлийн лавлагаа төвүүд, дүүргийн нэгдсэн эмнэлгүүдэд ЭМ-ийн байгууллагуудад цахим тогтолцоо нэвтрүүлэх нөхцөл байдлыг үнэлсэн.

5.3. Төслийн Хяналт-шинжилгээ, үнэлгээ

Төслийн дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээг улирлал тутамд хийж, тайланг төслийн захиралд танилцуулан, тайланг төслийн удирдах хорооны гишүүдэд хүргүүлж хэвшсэн.

5.4. Санхүүжилт

ТХН-ийн 2016 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газар, Дэлхийн банк, ТХН-ийн гурвалсан гэрээгээр “Нийслэл Аудит ХХК” гүйцэтгэлийн аудит хийлгэх гэрээ байгуулж, олон улсын стандартын дагуу санхүүгийн аудит хийлгэсэн. Төслийн санхүүгийн үйл ажиллагаа нь төсвийн тухай хууль болон Дэлхийн банкны санхүүгийн дүрэм журмын хүрээнд явагдаж байна. Цахим эрүүл мэнд төслийн 2017 оны төсвийг Удирдах хороогоор хэлэлцүүлэн батлуулж, Эрүүл мэндийн сайдын багцад оруулсан.

Батлагдсан төсвийн дагуу үйл ажиллагааны зардлыг улирлаар 4 удаа, үндсэн үйл ажиллагааны зардлыг тухайн бүрд нь Эрүүл мэндийн яам, Сангийн яамаар хянуулан батлуулж төлөвлөлтийн дагуу зарцуулалтыг хийж ажилласан.

Төслийн батлагдсан төсөвт үйл ажиллагааны дагуу үндсэн бүрэлдэхүүн хэсэг-1. Цахим эрүүл мэнд хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны хүрээнд 268,0 мян төгрөг төсөвлөснөөс 266,9 мян төгрөг, бүрэлдэхүүн хэсэг-2. Байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлж, чадавхжуулах хүрээнд 207,1 мян төгрөг төсөвлөснөөс 32,1 мян төгрөг, бүрэлдэхүүн хэсэг-5. Төслийн удирдлагын хүрээнд 557,9 мян төгрөг төсөвлөснөөс 455,8 мян төгрөгийг зарцуулж төсвийн гүйцэтгэл 73 хувийн зарцуулалттай байна. Тайлант хугацаанд Шилэн дансны аудитад хамрагдаж мэдээллийг цаг хугацаанд нь байршуулсан гэсэн дүгнэлт авсан. Жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд тайлагнахаар бэлтгэж байна. Төслийн санхүүгийн мэдээ, тайлагнал, төсвийн тухайн бүрд нь Odamis сайтад байршуулан ажилласан.

5.5. Төлөвлөгөөний биелэлт

ТХН-ийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт:

Төслийн бүрэлдэхүүн хэсэг	Эхний хагас жил		Сүүлийн хагас жил		Жилийн дүн	
	Ажлын тоо	Биелэлт хувь	Ажлын тоо	Биелэлт хувь	Ажлын тоо	Биелэлт хувь
1. Цахим эрүүл мэнд хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагаа	9	85.6	13	82.6	22	84.1
2. Эмнэлгийн өгөгдөл цуглуулах, хандах, солилцох	2	80.0	4	65	6	72.5
3. Үндэсний эрүүл мэндийн мэдээллийн төв	5	78.0	3	60	8	69
4. Байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлж, чадавхжуулах	3	86.0	3	95	6	90.5
5. Төслийн удирдлага	2	90.0	4	95	6	92.5
ДҮН	21	84.0	27	79.52	48	81.8

“Цахим эрүүл мэнд” төсөл хэрэгжүүлэх нэгж.